



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 03 сарын 16 өдөр

Дугаар A/155

Ховд


Захирамжийн хэрэгжилтийг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “а” “л” заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, аймгийн Онцгой комиссын хуралдааны 2020 оны 3 дугаар сарын 16-ны өдрийн 18 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Шинэ коронавирус /covid-19/-ын халдварын тархалтаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд аж ахуйн нэгж, байгууллага, дэлгүүр, үйлчилгээний байгууллагууд архи, согтууруулах ундаа худалдан борлуулахыг түр хориглосон аймгийн Засаг даргын 2020 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн A/150 дугаар захирамжийн хэрэгжилтийг 2020 оны 3 дугаар сарын 17-ны өдрөөс 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд сунгасугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Мэргэжлийн хяналтын газар /П.Эрдэнэчулуун/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ